



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 5/30

Хэрлэн сум

Тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.15, 30.1.16, 43 дугаар зүйлийн 43.1, 43.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Батширээт сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Цогзолмаа, Батноров сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Л.Баянмөнх, Галшар сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Оюунгэрэл нарт таван жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг олгосугай.

Хоёр. Тэтгэмжийг тухайн байгууллагын жилийн төсөвт багтаан олгохыг сургууль, цэцэрлэгийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА